



ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

67123. Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг  
Утас: 70382300, факс: 70381001  
www.khovsgol.gov.mn

2020. 07. 20 № 1/157  
танай 2020.01.10 -ны № 01/24 -т

Бүсчилсэн хөгжлийн бодлогод  
санал хүргүүлэх тухай

Үндэсний хөгжлийн газар Бүсчилсэн хөгжлийн бодлого боловсруулах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран зохион байгуулж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн төслийг боловсруулан ажиллаж байгаад талархал илэрхийлж байна.

Манай аймаг нь Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгах саналаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн бүс нутгийн онцлог тохирсон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, дэвшилтэд техник, технологи бүхий эдийн засгийг хангахуйц үйлдвэрүүд, нутгийн иргэдэд түшиглэсэн хамгаалалтын менежмент бүхий Ногоон аялал жуулчлалын загвар аймгийг цогцлоож дэд бүтэц болон эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж бүсийн аймгуудад нийлүүлэлт хийх үйлдвэрлэгч аймаг байх саналыг хүргүүлэн ажилласан.

Дээрх төслөөс харахад Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган, Архангай, Хөвсгөл, Завхан аймгийг "Хангайн эрчимжсэн хөдөө аж ахуй, аялал жуулчлал, ногоон хөгжлийн бүс" болгон Тэргүүлэх чиглэлээ Уламжлалт, болон эрчимжсэн хөдөө аж ахуй, Түүх соёлын аялал жуулчлал, Шинэ нийслэл гэсэн гурван хэсэгт хуваан цаг хугацааны хувьд гурван циклд хуваан 2021-2030 онд Орхон-Тамирын бэлчирт шинэ нийслэлийг байгуулан, төрийн захиргааны байгууллагуудыг шилжүүлж эхлэх, олон улсын жишигт нийцсэн үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлж, хойд урд бүсийг холбосон босоо тэнхлэгийг байгуулах, 2031-2040 онд Улиастай –Шинэ нийслэлд Улаанбаатарыг холбосон хурдны галт тэрэг, цахилгаан тээврийн дэд бүтцийг барьж байгуулах, 2041-2050 онд Ази-Европыг холбосон хамгийн дөт тэнхлэгийг байгуулж, нүүдлийн соёл иргэншил, Монгол туургатны өв уламжлалыг сонирхсон жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх гэж тодорхойлон Хөвсгөл аймагт Хөвсгөл нуурын эко систем, цаатангуудын уламжлалт ахуй соёл, томоохон голын ай сав дагуу аялал жуулчлалыг хөгжүүлэх заалт орсон хэмээн харж байна.

Хөвсгөл аймаг нь хүн ам, газар нутаг, малын тоогоор тэргүүлдэг дотоодын нийт бүтээгдэхүүнээр 6-д ордог байгалийн хувьд үзэсгэлэнтэй, хүн ам ерөнхийдөө залуу бүтэцтэй учир малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүд, байгалийн нөөц баялгийг түшиглэсэн боловсруулах үйлдвэрүүдийг тус тус байгуулан аялал жуулчлалыг хөгжүүлсэн үйлдвэрлэгч аймаг болгох алсын хараатай учир үүнийг Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгуулах саналтай байна.

ДАРГА



Л.ГАНБОЛД

01120056